



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/234

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4/в/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн IV хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 06/36 дүгнэлтийн хүрээнд Баян-Өндөр сумын гэр хорооллын багуудын зарим хэсэгт цасны шар ус их хэмжээгээр тогтож, айл өрх, авто зам усанд автсантай холбогдуулан үерийн сувгийн битүүрсэн хэсгийг сэргээж ухах, шаардлагатай цэгүүдэд шинээр суваг татаж, ус урсах нөхцөл бүрдүүлэх, шавар ихтэй гудамжнуудад хайрга асгаж тэгшлэх ажилд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх ажилд шаардагдах 5765425 /Таван сая долоон зуун жаран таван мянга дөрвөн зуун хорин таван/ төгрөгийг болзошгүй аваарийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
04 дүгээр сарын 26-ны өдрийн
237 дүгээр захирамжийн хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ГЭР ХОРООЛЛЫН ҮЕРИЙН
ДАЛАН СУВАГ СЭРГЭЭЖ УХАХ, ШИНЭЭР ТАТАХ
АЖЛЫН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

№	Зардлын нэр	Зардал / төгрөг/	Тайлбар
1	Түлш /шатахуун/	4505425	"НИК" ХК-ийн Орхон Петровис ШТС-3 шилжүүлэх
2.	Онцгой байдлын газрын албан хаагчид, ажилчдын өдрийн хоолны зардал	360000	"Цэц наран" ХХК-нд шилжүүлэх
3.	"Эрдэнэт-ус ДТС" ОНӨХК-ийн экскаватор /CAT-422E/-т засвар хийх зардал	900000	"Эрдэнэт-ус" ДТС ОНӨХК-д шилжүүлэх
	Нийт дүн	5765425	